

БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД  
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ

2025 оны 18 сарын 28-ны өдөр

Дугаар БА-090/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Баянзүрх дүүргийн 26 дугаар хороонд баригдсан дунд төвөгшилтэй ангиллын цоколийн давхартай 3-давхар 640 (зургаан зуун дөч) суудал бүхий хүчин чадалтай сургууль, спорт заалны барилга байгууламжид Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 212 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 гишүүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 02 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл

- 2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний дугаар: 0012891 зөвшөөрлийн дугаар: БАЗГ2023/306, огноо: 2023/06/07;
- 2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар: ГЛД-01/2022; ХАТ-12/22
- 2.3 Захиалагч: Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар ОНӨААТҮГ оноосон нэр, 9014001040 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5369622 регистрийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 23-р хороо, Арцатын аманд байрлах Нийслэлийн нутгийн захиргааны нэгдсэн цогцолбор барилгын "Б" блок 5 давхар, 11-324249 холбоо барих утас
- 2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: "Голден лайт групп" ХХК оноосон нэр, 9011380136 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, БУ12-537/24 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, 5659515 регистрийн дугаартай; Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 06 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, 63-р байр, утас:99112458, цахим хаяг: [altangerel@glg.mn](mailto:altangerel@glg.mn), [info@glg.mn](mailto:info@glg.mn)
- 2.5 Барилгын ажлын туслан гүйцэтгэгч байгууллага: Байхгүй
- 2.6 Зураг төсөл зохиогч байгууллага: "Голден лайт дизайн" ХХК оноосон нэр, 9011207094 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5325099 регистрийн дугаар, ЗТ11-857/22 Зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар; Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 06 дугаар хороо, Энхтайвны өргөн чөлөө, 63-р байр, утас:99111729, цахим хаяг: [ayush@glg.mn](mailto:ayush@glg.mn), [info@glg.mn](mailto:info@glg.mn)
- 2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Нийслэлийн боловсролын газар оноосон нэр, 9077065 регистрийн дугаар;

Хаяг: Багшийн хөгжлийн ордон, Энхтайвны өргөн чөлөө 10 а, 11 дүгээр хороолол, 8 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Утас: 70113033 цахим хаяг: www.edub.edu.mn

## 2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

### ✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул

### □ Барилга байгууламжийг ашиглалтад оруулахаас татгалзах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангаагүй, барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдээгүй, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй тул
- Заасан хугацаанд үүрэг даалгаврын биелэлт хангаагүй тул

3.1 Энэ дунд төвөгшилтэй ангиллын цоколийн давхартай 3 давхар 640 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.2 Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;

б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх;


### 3.3 Ашиглагч байгууллагад:

а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;

б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;

в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.4 Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 6 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 15 хуудас материал болон барилга



байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох ... хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Дунд төвөгшилтэй ангиллын цоколийн давхартай 3 давхар 640 (зургаан зуун дөч) хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар  
ОНӨААТҮГ-ийн захиалгатай цоколийн давхартай 3 давхар 640 хүүхдийн  
суудалтай сургууль, спорт заалны барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч:

Нарийн бичгийн дарга:  
Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын  
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.



БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ 26-Р ХОРОО НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН  
ГАЗРЫН ЗАХИАЛГАТАЙ ЦОКОЛИЙН ДАВХАРТАЙ 3 ДАВХАР 640 ХҮҮХДИЙН  
СУУДАЛТАЙ СУРГУУЛЬ, СПОРТ ЗААЛНЫ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ  
АШИГЛАЛТАД ОРУУЛАХ КОМИССЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 02 дугаар сарын 17-ны өдөр

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай цоколийн давхартай 3 давхар 640 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын хуралдаан тус барилгын нэгдүгээр давхарт 2025 оны 02 дугаар сарын 17-ний өдөр 10:00 цагт 15 гишүүний бүрэлдэхүүнтэй эхэлж, 12:00 цагт дуусав.

Хуралд:

- |   |                |
|---|----------------|
| 1. Комиссын дарга: Хяналт шалгалтын газар, Барилга байгууламжийн ашиглалт, бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч: | А.Мөнгөн       |
| 2. Комиссын нарийн бичгийн дарга: Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн дарга:                               | Б.Ганзориг     |
| 3. Хяналт шалгалтын газрын, Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын байцаагч:              | Н.Ёндонсамбуу  |
| 4. Хяналт шалгалтын газрын дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн эрчим хүчний хяналтын улсын байцаагч:                                   | Э.Цогзолбаа    |
| Нийслэлийн онцгой байдлын газар, Гал түймэртэй тэмцэх хэлтсийн Барилгын зураг төсөл хяналтын байцаагч /Ахмад/                             | Б.Дөл-Эрдэнэ   |
| 6. Улаанбаатар дулааны сүлжээ ТӨХК, Ахлах инженер   | Б.Оргил        |
| 7. Титан грид ХХК-ийн инженер   | Д. Дэлгэрхи    |
| 8. Мэдээлэл холбооны сүлжээ ТӨХК, ДБТХ-ийн мэргэжилтэн  | Э. Уранчимэг   |
| 9. Ус сувгийн удирдах газар, Хэрэглэгчид үйлчлэх албаны менежер   | Ө.Шинэцэцэг    |
| 10. Барилгын хөгжлийн төв, барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн   | Б. Жаргал      |
| 11. Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо МСҮТ-н захирал, хүртээмжийн үнэлгээний ажилтан   | Б. Ганзориг    |
| 12. Үндэсний Төв архив, Зураг төслийн баримтын архивч   | Н. Өлзийжаргал |
| 13. Нийслэлийн боловсролын газрын мэргэжилтэн /Ашиглагч байгууллага/  | Д.Ирмүүнзаяа   |
| 14. Зураг төслийн “Голден лайт дизайн” ХХК-ийн ерөнхий инженер  | Б. Алтансүх    |
| 15. Гүйцэтгэгч “Голден лайт групп” ХХК-ийн ерөнхий инженер  | Л. Биндэръяа   |

## ИРЦИЙН БАЙДАЛ

- Мэдэгдэл хүлээн авсан – 15
- Хуралд оролцож үүрэг даалгаврын биелэлтээр санал гаргасан–15

## ХЭЛЭЛЦСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 26-р хороо Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын захиалгатай цоколийн давхартай 3 давхар 640 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга байгууламжийг ашиглалтад оруулах шаардлага хангасан эсэх талаар хэлэлцэв.

## СОНССОН НЬ:

Комисст ажилласан гишүүд барилга байгууламжийн зураг төсөл, баримт бичиг, барилгын ажлын гүйцэтгэлийг хянаж танилцаад дараах саналуудыг гаргав.

Нийслэлийн хяналт шалгалтын газрын дарга, барилга байгууламжийн ашиглалт, бүртгэл хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч:

### **А.Мөнгөн:**

- БНБД-ийн 11-04-16 дагуу зохиогчийн нэгдсэн дүгнэлт дээр зурагтай холбоотой өөрчлөлт бүрийг тусган эцэслэн бичих
  - БТХ-ийн 14.3, 14.6 дагуу чанарын баталгааны албан тоот ирүүлэх
  - В1 давхрын цонхнуудад аюулгүй байдлыг хангуулах хаалт хийх
  - Барилгын хойд хэсгийн хаяавчийг гүйцээх
  - Газартай холбоотой маргаанаас болж газрын хэмжээ багассан тул одоогийн олгогдсон газрын хэмжээнд тааруулан загвар зургийг батлуулах
  - Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу гадна тохижилтыг хийх
  - Барилгын гадна хашааг хийж гүйцэтгэх
  - Газрын маргаантай холбоотой бичиг баримтыг хянуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн хяналт шалгалтын газар, барилгын стандарт, аюулгүй байдалын хяналтын хэлтсийн барилгын техникийн хяналтын улсын байцаагч

### **Н.Ёндонсамбуу:**

- Шилэн хийцлэлд гарал үүслийн гэрчилгээ, холбоотой баримт бичгийг шалгуулах
- Барилгын тухай хуулийн дагуу баталгаа гаргаж ирүүлэх 14.3, 14.6
- Ерөнхий төлөвлөгөө тайлбар албан тоот ирүүлэх шаардлагатай бол дахин батлуулах
- Орц, гарцны асуудал шийдэх /зөвшилцөх/
- Лабораторын шинжилгээ нөхөж үзүүлэх
- Барилга хоорондын зай хэмжээний талаар тайлбар өгөх /хэмжилт байр зүйн зураг хийлгэх/
- Зөвшилцсөн албан тоот шүүхтэй холбоотой бүх албан тоотуудыг үзүүлэх 1 хувь өгөх

Татгалзах саналтай байна.



Нийслэлийн хяналт шалгалтын газар, дэд бүтцийн стандарт хяналтын хэлтсийн Эрчим хүчний хяналтын улсны байцаагч

#### **Э.Цогзолмаа:**

- Гадна дулаан механикийн гүйцэтгэлийн зургийг хангагч байгууллагаар баталгаажуулж шалгуулах
  - Огтолгоо авсан цэгээс хангагч байгууллагатай зөвшилцсөн албан бичгийг шалгуулах
  - Узелийн өрөөний моторын дуу чимээ хэмжүүлж хэмжилтийн дүнг шалгуулах
  - Хоолны газар болон спорт, урлаг заалны агааржуулалтын системийн дуу чимээг хэмжүүлж хэмжилтийн дүнг шалгуулах
  - АЦӨ-ний ердийн агааржуулалтын системд зохиогч тайлбар албан тоот ирүүлэх
  - Дээвэр дээрх АС-г дифлектрээс дээш бохирын хоолойг өндөрлөж фото зургаар баталгаажуулах
  - УБДС ТӨХК-аас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар дулааны сүлжээ ЗТТ-ийн, ахлах инженер

#### **Б.Оргил:**

- Гадна дулааны гүйцэтгэлийн зураг экспертээр оруулах, хангагч байгууллагаар хянуулах
  - Гадна дулааны шугамын нягтын шахалтын акт дахиж хийх, баталгаажуулах
  - Халаалт хэрэгцээний халуун усны ялтсан халаагуурын хүчин чадлыг техник ашиглалтын дүрмийн дагуу зураг төслөөс 20%-ийн нөөцийг сонгож угсрах
  - Термостат вентиль дутуу гүйцээж угсрах
  - Гадна дулааны шугам нийслэлийн мэдээллийн санд өгөх
  - Босоо шугамуудын төгсгөлд автомат хий авагч угсрах
  - Гадна дулааны шугамын огтолгоо авч угсралт хийсэн шугам эзэмшигч зөвшилцсөн албан тоот бичиг баримт шалгуулах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Титан грид ХХК **Д.Дэлгэрхи**

- Ерөнхий шит ОЕС-н АВР хийх
  - Урлаг заал спорт зааланд аваарын гэрэл хийх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Мэдээлэл холбооны сүлжээ, Дэд бүтэц төлөвлөлтийн мэргэжилтэн

#### **Э.Уранчимэг:**

- Шинээр хийсэн сувагчилалаа нийслэлийн мэдээллийн санд тусгуулж МХС-д техникийн актаар хүлээлгэж өгөх
- Дотор холбоо болон гадна холбооны ажил гүйцэтгэлийн зургийг баталгаажуулах
- Шинээр хийгдсэн худгийн тагийг солих. Сургуулийн орц гарцны үүдэн хэсэгт

байгаа учир зузаан таг хийх (фото зургаар баталгаажуула)

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Улаанбаатар хот Ус сувгийн удирдах газар, менежер

#### **Ө.Шинэцэцэг:**

- Цэвэр усны огтолгоон дээр фланзтай хаалт угсрах
- БУХ-2-ийн ажлын талбайг трап гаргаж засаж цэвэрлэх
- Гал тогооны угаалтуурын дор элс, тос баригч суурилуулах
- Хөрс борооны усныг бохир усны шугаманд нийлүүлэхгүй байх
- Тоолуурын мэдээллийг үнэн зөв өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн онцгой байдлын газар, гал түймэртэй тэмцэх хэлтсийн барилгын зураг төслийн хяналтын байцаагч

#### **Б.Дөл-эрдэнэ:**

- Гал түймэр унтраах даралтын хоолой техникийн шаарлага MNS6576 стандартын дагуу хоолой хушууны шошго хомут солих /Балданов шошго/
- Барилгын гадна дулаалга ил далд ажлын акт нөхөж үзүүлэх
- Минни спорт заалнаас гадагш гарсан аваарын шат хийж гүйцэтгэх шаардлагатай
- Гал унтраах автомашины орц. Гарц төлөвлөх
- Гадна цахилгаан хангамж хаалттай дэд өртөөний талаар зай хэмжээ хэрхэн хангуулж байгаад автор дүгнэлт гаргаж өгөх
- Галын дохиоллын мэдээлэгч, утаа
- Галын дохиоллын мэдээллэгч, утаа мэдрэгчийн тагийг авах
- Аваарын гарц шатны тавцанг хүчитгэх
- Аврах зам гарцны тэмдэг тэмдэгдэгээг хийж гүйцэтгэх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Үндэсний төв архив, Зураг төслийн баримтын архивч

#### **Н.Өлзийжаргал:**

- Зохиогчийн хяналтын гэрээ хийх, газартай холбоотой бичиг баримт, зураг төсөлд эрүүл ахуйн байцаагчийн дүгнэлт, захиалагчийн дүгнэлт чанарын баталгааг хувийн хэрэгт жагсаалтын дагуу хавсаргах
- Далд ажлын актыг бүрэн бүрдүүлж гарын үсгийн бүрдлийг гүйцээж баталгаажуулах
- Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэлийг баталгаажуулах
- Баримт бичгийн хуудас дугаарлаж, дотоод товъёг үйлдэх
- Ажлын зураг болон холбогдох баримт эх хувийг архивд хуулбар хувийг ашиглагч байгууллагад хүлээлгэн өгөх

Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Барилгын хөгжлийн төв, барилга барилгын материалын үйлдвэрлэлийн хэлтсийн мэргэжилтэн

#### **Б.Жаргал:**

- Барилгын тухай хуулийн дагуу норм нормативын санд төлбөр төлөх
- Урлаг зааланд хөвөө хийх
- 3-р Давхрын хананд үүссэн хялгасан хагарлыг засварлах
- Дүүжин таазны дээж шилжилгээнд өгөх
- Дотор болон гадна хаалга, хананд хийгдсэн шилний шинжилгээг ирүүлэх
- Анги танхимд байрлах баганын буланг хавтгай болгох, хамгаалатын булан наах
- Анги танхимын халаах хэрэгсэлийг хамгаалах хаалт хашлага хийх
- Гадна хашааг бүрэн хийх
- Гадна зоорийн хананы зураг төслийн дагуу хийх /120мм тоосгон хана/  
Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Монголын хараагүйчүүдийн үндэсний холбоо МСҮТ-н захирал, хүртээмжийн үнэлгээний ажилтан

#### **Б.Ганзориг:**

- Гадна авто зогсоол дээр хөгжлийн бэрхшээлтэй хүний тэмдэглэгээ бүхий авто зогсоол хийх /6.5м доошгүй байх/ авто замаас зогсоолруу орох хэсэгт налуу зам хийх
  - Орц хэсгийн налуу зам дээр байгаа бариулыг хийх
  - Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан ариун цэврийн өрөөнд тоноглол суулгах
  - Бүх шатны 2 талд бариул хийх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Ашиглагч: Нийслэлийн боловсролын газар

#### **Д.Ирмүүнзаяа:**

- Гадна тохжилтын ажил, хашааг стандартын дагуу бүрэн хийж дуусгах, аюулгүй байдал хангуулах
  - Гал тогооны өрөөнд 3 дамжилагт угаалтуур, тос баригч хийж өгөх
  - Гал тогооны шилэн хийц хамгаалах хуулга наах
  - Спорт заал пүлт удирдлага самбарын байршилыг өөрчлөх, өсгөгч бэхэлгээ сайжруулах хамгаалах
  - Дотор заслын ажил сайжруулах хана, хаалга шалны хүрээ хийх
  - Барилгын хувийн хэрэг үүсгэж өгөх
  - Холбогдох зураг төсөл, баримт бичгүүдийг 183-р сургуульд хүлээлгэн өгөх
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Зураг төсөл зохиогч

“Голден лайт дизайн” ХХК ерөнхий инженер **Б.Алтансүх:**

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна

Гүйцэтгэгч

“Голден лайт групп” ХХК ерөнхий инженер **Л.Биндэръяа:**

- Комиссын гишүүдийн өгсөн үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын Барилга захиалагчийн хэлтсийн хяналтын инженер

#### Г.Буянжаргал:

- Комиссын гишүүдийн үүрэг даалгаврыг биелүүлэх
  - Дүүжин таазыг шинжилгээнд өгөх шаардлагатай гэж үзвэл төмөр таазаар солих
  - Баримт бичгийн бүрдэлийг бүрэн хангах
- Үүрэг даалгаврын биелэлтээр ашиглалтад оруулах саналтай байна.

#### ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Баянзүрх дүүргийн 26 дугаар хороо Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын захиалгатай цоколийн давхартай 3 давхар 640 хүүхдийн суудалтай сургууль, спорт заалны барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын гишүүдийн гаргасан үүрэг даалгаврын биелэлтийг хангуулах, биелэлтээр комиссын дүгнэлт үйлдэх, баталгаажуулах, ашиглалтад оруулахаар шийдвэрлэв.

Танилцсан:


Комиссын дарга: Хяналт шалгалтын газрын  
Барилга байгууламжийн ашиглалт,  
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч:



/А. Мөнгөн/

Тэмдэглэл хөтөлсөн:

Комиссын нарийн бичгийн дарга:  
Нийслэлийн хөрөнгө оруулалтын газрын  
Барилга захиалагчийн хэлтсийн дарга



/Б.Ганзориг/